



ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ
ДАРГА О.БАТ-ЭРДЭНЭ ТАНАА

МОНГОЛ УЛС
АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР

14250 Улаанбаатар хот. Сүхбаатар дүүрэг,
Суулын гудамж 41, Утас: 7011-0251, Факс: (976) 7011-0251,
E-mail: comcon@iaeac.mn, http://iaeac.mn

2017/10/31 № 05/7801
төний 2017/10/20 № 1/28 -т

Хувийн ашиг сонирхлын урьдчилсан
мэдүүлэг хянасан тухай

Дундговь аймгийн Өлзийт сумын цэцэрлэгийн эрхлэгчийн албан тушаалд томилогдохоор нэр дэвшсэн Цэрэндэжидийн Наранбаатарын хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэгийг Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зерчлэес урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.6 дахь хэсэгт заасныг үндэслэн хянан үзэхэд ашиг сонирхлын зөрчил үүсэх нөхцөл байдал одоогоор тогтоогдоогүй болно.

Нэр дэвшигч Ц.Наранбаатар нь Сургуулийн өмнөх боловсролын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1-д "терийн болон төрийн бус өмчийн цэцэрлэгийг сургуулийн өмнөх боловсролын багш бэлтгэдэг их, дээд сургууль, коллеж төгссөн, ажлын туршилагатай эрхлэгч удирдах бөгөөд түүнийг үүсгэн байгуулагч томилино" гэснийг, түүнчлэн Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 60 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсан "Төрийн үйлчилгээний албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам"-ын 7 дугаар хэсгийн 7.5 "терийн үйлчилгээний албаны удирдах албан тушаалын сүл орон тоо гарсан тохиолдол бүрт сонгон шалгаруулалтыг шинээр зохион байгуулна", 8 дугаар хэсгийн 8.4 "Сонгон шалгаруулалтад ороогүй иргэнийг удирдах албан тушаалд томилохгүй" гэж заасныг тус тус зөрчихээр байна.

Иймд нэр дэвшигчийг Төрийн албаны тухай хууль, бусад салбарын хууль тогтоомж болон ажлын байрны тодорхойлолтод заасан шаардлага, шалгуур үзүүлэлтийг хангаж буй эсэхэд хяналт тавьж, Төрийн албаны зөвлөл, салбар зөвлөлийн санал, дүгнэлтийг үндэслэн холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн шийдвэрлэнэ ўу.

ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ДУН
ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН ДАРГА,
ЭРХЭЛСЭН КОМИССАР



Х.ХАШБААТАР

Ангийн тогтолцоог тогтоогдоогүй
РЗД-ийн бүрчигчийн тогтолцоог тогтоогдоогүй
2018.01.08-ийн
орчны б/н
зөвлөлийн
тогтолцоог тогтоогдоогүй
Г.Борисов
15584